

ATA14401 9025010818 5890683

№	Хэлэлцэх асуудал	Хугацаа /минут/	Асуудал танилцуулах албан тушаалтан	Гарах шийдвэр
1	Байгууллагын 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн А/10 тоот даргын тушаалаар байгуулагдсан тооллогын комиссын саналыг үндэслэн байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн гишүүд болон нягтлан, няравыг оролцуулан тээврийн хэрэгслийн актлуулах	30	Зөвлөлийн дарга	Тэмдэглэл

НАЛАЙХЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРКИЙН
ӨМЧ ХАМГААЛАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2025.01.03.

Налайх дүүрэг

Налайхын үйлдвэрлэл, технологийн паркийн дэргэдэх өмч хамгаалах зөвлөлийн хурлыг газрын даргын өрөөнд 2025 оны 01 дугаар сарын 03-ны өдрийн 6:00 цагт эхэлж 16:30 цагт дуусгав. Хуралд өмч хамгаалах зөвлөлийн дарга Н.Пүрэвсүрэн гишүүд Э.Энгүүн, О.Чулуун-Эрдэнэ, Г.Ганцэцэг нар болон нярав Э.Ундармаа нар оролцов. Хурлын ирц 100 хувь.

ХЭЛЭЛЦСЭН НЬ: Байгууллагын 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн А/10 тоот даргын тушаалаар байгуулагдсан тооллогын комиссын саналыг үндэслэн байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн гишүүд болон нягтлан, няравыг оролцуулан тээврийн хэрэгслийг актлуулах.

СОНССОН НЬ: Байгууллагад бүртгэлтэй элэгдлээрээ зардлаа бүрэн нөхсөн, эвлэрч, засах боломжгүй болсон 2005 оны Санато-6 маркийн 0012 УНА улсын дугаартай авто тээврийн хэрэгслийг актлуулах.

Н.Пүрэвсүрэн: Уг тээврийн хэрэгсэл маань сүүлийн 3 жил огт яваагүйг та бүхэн мэдэж байгаа байх. Одоо энэ машиныг засах боломжгүй болсон учир Нийслэлийн өмчийн харилцааны газар санал хүргүүлэн актлуулах саналтай байна. “Мөнх ерөөлт интернэйшнл” ХХК-аас техникийн комиссын акт гарсан байгаа тул бүгд уншиж танилцаад санал хэлнэ үү.

О.Чулуун-Эрдэнэ: Энэ машин 2008 оноос хойш байгууллагын үйлчилгээнд явсан. Сэлбэг хэрэгсэл нь олдохгүй хэцүү. Сүүлийн хэдэн жил техник хяналтын оношилгоонд ороод тэнцэхгүй байж байгаад одоо мотор хроп бүрэн эвдэрсэн. Явах эд анги зэвд идэгдэж засварлах боломжгүй болсон. Гражид олон жил хээтлээ. Актлах нь зүйтэй.

Г.Ганцэцэг: Энэ машин засаж сэлбэж унах боломжгүй гэж үзэж байгаа тул санал нэгтэй байна. Сэлбэг хэрэгсэл нь олдоц муутай. Дээрээс нь засварлах зардал ч байхгүй байна.

Э.Энгүүн: Засвар үйлчилгээ авахгүй, үхмэл хөрөнгийг зохих журам дүрмийн дагуу данснаас хасуулах нь зүйтэй гэж бодож байна.

Э.Ундармаа: Энэ машин засвар үйлчилгээ авахгүй. Явах эд анги, мотор хроп бүрэн элэгдэж дууссан. Машиныг актлах нь зүйтэй. Санал нэгтэй байна.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ: Налайхын барилгын материал үйлдвэрлэл, технологийн паркийн дансанд бүртгэлтэй 0012 УНА дугаартай авто тээврийн хэрэгслийг актлуулах саналыг холбогдох материалын хамт Нийслэлийн өмчийн харилцааны газар хүргүүлэхээр болов.

Тооллогын комиссын
Дарга
Гишүүд



Н.Пүрэвсүрэн /Ахлах мэргэжилтэн/
Э.Энгүүн /Маркетинг, ОНХХ мэргэжилтэн/
О.Чулуун-Эрдэнэ /Гадаад харилцаа, хамтын
ажиллагааны мэргэжилтэн/
Г.Ганцэцэг /Нягтлан бодогч/
Э.Ундармаа /Нярав/

ATA14401 9025010818 5890683